



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/175

Улаанбаатар хот

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал
ба тодорхойлолт 08-д нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-ын 2 дугаар хавсралтаар батлагдсан үндэсний индекс/код дахь 2621 нэгж бүлэгт “2621-27 Сан хөмрөгч”, “2621-28 Сэлбэн засагч”, “2621-29 Баримт ариутгагч”, “2621-30 Архивын баримтын хадгалалтын технологич”, 1120 нэгж бүлэгт “1120-54 Захирал, гүйцэтгэх захирал, архивын” гэж тус тус шинээр нэмсүгэй.

2. Үндэсний индекс/кодын “2621-16 Арга зүйч, архивын” гэснийг “2621-16 Зааварлагч, арга зүйч, архивын” гэж, “2621-18 Мэргэжилтэн, архив судлаач” гэснийг “2621-18 Архив судлаач, эрдэм шинжилгээний ажилтан” гэж, “2621-19 Мэргэжилтэн, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартчиллын” гэснийг “2621-19 Байцаагч, архивын” гэж тус тус нэршилд өөрчлөлт оруулсугай.

3. Шинээр нэмсэн болон өөрчлөлт оруулсан ажил, мэргэжлийн мэдээллийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

4. Архивын байгууллагуудад энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан ажил, мэргэжлийн ангиллыг үндэслэн ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолт боловсруулах, хөдөлмөрийн норм норматив тогтоохдоо мөрдөхийг зөвлөсүгэй.

САЙД



Х.БУЛГАНТУЯА

2621-19 Байцаагч, архивын

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Inspector, archives

Ажлын байрны тодорхойлолт: Архивын байцаагч нь архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх эрх бүхий байгууллагаас гаргасан бусад шийдвэр, эрх зүйн актын биелэлтийг хангана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч

2621-27 Сан хөмрөгч

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Treasurer

Ажлын байрны тодорхойлолт: Архивын сан хөмрөгийн бүрдүүлэлт, баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалт, тоо бүртгэл, хөтлөлтийн ажлыг хариуцан ажиллана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Сан хөмрөгийн эрхлэгч
- Фондч

2621-28 Сэлбэн засагч

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Spare parts

Ажлын байрны тодорхойлолт: Архивын баримтын хими, физик, техникийн шинж чанарт үзлэг хийх, гэмтлийн зэрэг, төрлийг тодорхойлох, баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх, ажлыг гүйцэтгэнэ.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Сэргээн шинэтгэгч

2621-29 Баримт ариутгагч

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Document disinfectant

Ажлын байрны тодорхойлолт: Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг тодорхойлох, баримтад технологийн карт хөтлөх, гэмтэл, бохирдлын хими, физик чанарыг тодорхойлох, уусмал бэлтгэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

2621-30 Архивын баримтын хадгалалтын технологич

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Archival document storage technologist

Ажлын байрны тодорхойлолт: Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдал, баримтын шинж чанарт үзлэг явуулах, судалгаа хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, гэмтлийн зэргийг тодорхойлох, сэргээн засварлах баримтад технологийн карт хөтлөх, баримтжуулах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны 1 дугаар сарын 06 ны өдрийн
1/12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1120 Захирал, гүйцэтгэх захирал

1121-54 Захирал, гүйцэтгэх захирал, архивын

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Director, deputy manager, archives

Ажлын байрны тодорхойлолт: Архивын захирал, гүйцэтгэх захирал нь тухайн салбарын болон орон нутгийн хэмжээнд албан хэрэг хөтлөлт, архивын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хуулиар заасан архивын чиг үүргийг хэрэгжүүлэх, архивын болон ажилтнуудын хийж гүйцэтгэх ажлыг удирдан, зохион байгуулах үүрэгтэй ажиллана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Төрийн архивын захирал
- Төрийн архивын дарга
- Архивын эрхлэгч

2621 Архивч, музейн харгалзагч

2621-16 Зааварлагч, арга зүйч архивын

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Instructor-methodologist

Ажлын байрны тодорхойлолт: Төрийн болон байгууллагын архивын үйл ажиллагаанд мөрдөгдөх арга зүйн баримт бичиг боловсруулах, судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хөмрөг үүсгэгч байгууллага, иргэн, архивуудтай хамтран ажиллаж, мэргэжил-арга зүйн туслалцаа үзүүлж, зааварчилгаа зөвлөгөөгөөр хангаж ажиллана.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Ахлах архивч
- Архивын зааварлагч-арга зүйч

2621-18 Архив судлаач, эрдэм шинжилгээний ажилтан

Ажил, мэргэжлийн нэр /Англиар/: Researcher, archives

Ажлын байрны тодорхойлолт: Архивын сан хөмрөгийн баримтад судалгаа хийж, тэдгээрийг олон нийтэд сурталчилан танилцуулах, төрийн архивт хадгалагдаж буй баримтын эрэл хайлтыг хөнгөн шуурхай болгох зорилгоор тойм, танилцуулга, каталог зэрэг холбогдох эрдэм шинжилгээний лавлахууд зохиох, архивын баримтын хэвлэн нийтэлж, сурталчилна.

Ажил, мэргэжлийн жишээ:

- Архивч